



СОЁМБОМ ЭДЭЭ

ТУСГАЙ ДУГААР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ДУГААР АНГИЙН 10 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ!



МЭНДЧИЛГЭЭ



Зэвсэгт хүчний 350 дугаар анги үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан тус ангиас төрөн гарсан генерал, офицер, ахлагч, өөрийн залуу нас, оюун ухаан, хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээ ангийнхаа хөгжил дэвшилд зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, гавьяаныхаа амралтад гарсан ажилтан албан хаагч, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй бие

давхцан нэгэн шинэ зуунтай зэрэгцэн тохиож байгаагаараа онцлог байна.

Бид бүхэн өнгөрөгч жилүүдэд төр засаг, цэргийн дээд командлалаас өгсөн үүрэг даалгавруудыг ёсчлон гүйцэтгэж, тайван цагийн болон дайны байдлын үед гүйцэтгэх үүргийн хүрээнд ангийн байлдааны бэлэн байдлын бичиг баримтуудыг шинэчлэн боловсруулж, штаб, салбаруудын үүрэг гүйцэтгэх чадвар, бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлж, ангийн барилга байгууламжуудыг шинээр бүтээн босгох нөр их ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангахын зэрэгцээ цэргийн сургалт бэлтгэлийг эхлүүлж, алба хаагчдынхаа ажиллаж, сурч боловсрох аятай нөхцөлийг бүрдүүлэн, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах биеийн тамир, спортын уралдаан тэмцээнүүдэд тамирчин дайчдаа оролцуулж эхэлснээр 2018-2019 оны сургуулийн жилийн нэгдсэн дүнгээр "Тэргүүн байр", цэргийн сургалт бэлтгэлийг тогтмолжуулж, хээрийн гаралт, байлдааны буудлага, полигоны дадлагуудыг тогтмол явуулснаар 2019-2020 оны сургуулийн жилд анх удаагаа цэргийн сургалт бэлтгэлээр "Хошуучлагч анги"-ийн болзлуудыг ойн жилийн босгон дээр хангаж, бахдам амжилтуудыг үзүүлээд байна.

Бид гадаадын улс орны Зэвсэгт хүчнүүдтэй хамтарсан болон өөрийн оронд зохион байгуулагдсан команд штабын сургуулиуд, Энхийг сахиулах ажиллагааны салаадын хээрийн сургуульд офицер, ахлагч нараа оролцуулж мэдлэг, дадлага, ур чадварыг нь нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон Эвслийн цэргийн ажиллагаануудад давхардсан тоогоор 1000 гаруй алба хаагчдыг бэлтгэн илгээсэндээ захирагчийн хувьд сэтгэл хангалуун байна.

Зэвсэгт хүчний эгнээнд мөр зэрэгцэн алба хааж байгаа ангийн нийт бие бүрэлдэхүүндээ өргөсөн тангарагтаа үнэнч, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх үйлсэд шантралгүй, хариуцлагатай байж, эрхэм хүндтэй албаа нэр төртэй хаахын сацуу ангийнхаа өмнөө тавьсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйлсэд манлайлан оролцож, эрхэлсэн албандаа улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

МОНГОЛ ЦЭРГИЙН МЭЛМИЙ ТУНГАЛАГ, ӨЛМИЙ БАТ ОРШИГ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Ж.СҮХ-ОЧИР

БИД ГЭРЭЛ ЗУРГИЙН ХАЛЬСНАА



ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ 3 ДАХЬ МОТОБУУДЛАГЫН ТУСГАЙ БАТАЛЬОН



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.1.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны м/н 77 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2011 оны м/н 10, ЗХЖШ-ын даргын 2011 оны н/26 дугаар тушаалаар тус анги байгуулагдсан түүхтэй.

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийг байгуулах дээд газрын тушаал шийдвэр хэрэгжиж эхэлсэн өдөр болох 2012 оны 6 дугаар сарын 15-ний билэгт сайн өдөр Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэр Гандан уулын өвөр, Дархан ноёны худаг хэмээх тэгш сайхан талд "Энхийг сахиулах ажиллагааны 3 дахь мотобуудлагын тусгай батальон" буюу Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн шав тавих ажиллагааг ёслол төгөлдөр хийжээ.

Уг ажиллагаанд Улсын их хурал, Засгийн газрын гишүүд, Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлага, орон нутгийн засаг захиргааны удирдлагын хүмүүс болон Бүгд

Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай Энхийг дэмжих ажиллагаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн I ээлжийн бүрэлдэхүүн оролцсон байдаг.

Тус ангийн анхны захирагчаар хурандаа Ж.Мөнхбаяр 2012 оны 7 дугаар сарын 3-ны өдөр томилогдож байлаа.

2012 оны 10 дугаар сарын 28-ны өдөр ЗХЖШ-ын барилга орон сууцны хэлтсийн дарга, хурандаа н.Цэнд-Аюуш, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч, хурандаа Л.Балдан-Очир, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр, тус ангийн ар талын дарга,

хурандаа Б.Ринчиндэндэв, санхүүгийн дарга, ахмад Х.Чандалмаа, сувилагч Б.Алимцэцэг, салааны захирагч, дэслэгч П.Бүрэнтөгс нарын бүрэлдэхүүн ангийн бүтээн байгуулалтын шавыг тавьж хүндэтгэл үзүүлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.1.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны м/н 77 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2011 оны м/н 10, ЗХЖШ-ын даргын 2011 оны н/26 дугаар тушаалаар тус анги байгуулагдсан түүхтэй.

БИДНИЙ БАХАРХАМ ОН ТООЛОЛ

2011-2012

Анги байгуулагдах дээд газрын тушаал шийдвэр гарч, шавыг тавьж анхны захирагч томилогдсон.
Мөн үйл ажиллагаа явуулах гэрчилгээг авч, ангийн лого уриаг бий болгов.

2013

Ангийн бүтээн байгуулалтын ажлууд өрнөж, анхны төгсөгч нараа хүлээн авч, анхны энхийг сахиулагч нараа газар оронд илгээсэн.

2014

Ангийн байлдааны туг, барилга байгууламжуудаа хүлээн авч, ангийн уурын зуухны галлагааг эхлүүлж, байнгын ажиллагаатай болов.

2015

Анхны байлдааны буудлагатай сургууль, Индонези Улсад явагдсан энхийг дэмжих ажиллагааны сургалтад эх орноо төлөөлөн оролцсон.

2016

"Монгол цэргийн жавхаа" уралдаанд дэд байр, "АСЕМ"-ийн хамгаалалт, Монгол-Катарын хамтарсан сургууль

2017

Непаль Улсад явагдсан энхийг дэмжих ажиллагааны сургалтад эх орноо төлөөлөн оролцсон.

2018

"Восток-2018" стратегийн сургуульд эх орноо төлөөлөн оролцсон.

2019

Биеийн тамир, спортын "Тэргүүний анги"-аар шалгарлаа

2020

Цэргийн сургалт бэлтгэлээр "Хошуучлагч анги", "Сахилгын зөрчилгүй тэргүүний хамт олон" дэд байр

2021

НҮБ-д үүрэг гүйцэтгэх Түргэн байрлах хүчний ротыг амжилттай шалгууллаа.

АНГИАС ТӨРСӨН АЛДАРТНУУД

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛТНУУД

Бригадын генерал-Б.Эрдэнэбат,
Хурандаа Ж.Мөнхбаяр, Б.Ринчиндэндэв,
Д.Өлзийбаяр, Н.Мягмарцож, Ж.Сүх-Очир, О.Заяат,
Х.Эрдэнэчимэг, Л.Дагвасүрэн
Дэлхийн аварга
Л.Тэмүүлэн /Таеквондо/
Ази тивийн аварга
Э.Гэрэлтуяа /Радиоспорт/
ОУХМ Ц.Отгонтөгс мөнгө, хүрэл /Чөлөөт бөх/
Олон улсын тэмцээн
С.Нандин-Эрдэнэ 2 алт, 1 мөнгө /Туухай өргөлт/
Ц.Отгонтөгс алт, мөнгө
Ц.Жавхлантөгс мөнгө, хүрэл
М.Аюурзэд мөнгө, хүрэл /пауэрлифтинг/
Үндэсний бөх
Монгол Улсын аварга П.Бүрэнтөгс
Монгол Улсын харцага Б.Бат-Өлзий
Монгол Улсын харцага Ц.Одбаяр
Монгол Улсын начин У.Балжинням
Аймгийн арслан Ч.Мөнхтогтох
Цэргийн арслан Г.Жамбалдорж
ОУХМ-2, Спортын мастер-16 төрөн гарсны зэрэгцээ олон дэд мастер, спортын зэрэгтнүүд түүчээлж яваа билээ.

ДУРДАТГАЛ



байна.
Хэдийгээр 10 жилийн түүх гэдэг богинохон хугацаа боловч та бүхэн Монгол цэрэг эх орон, ард иргэдийнхээ өмөг түшиг байж, төрт улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, монгол түмнийхээ тайван амгалан амьдралын баталгаа, мандан бадрахын бэлгэ тэмдэг болж ирсэн түүхтэй. Цэрэг арми хүнийг зовлонд гундаагүй, жаргалд ташуурдаггүй болгож хүмүүжүүлдэг билээ. Зэвсэгт хүчний 350 дугаар анги үүсэн байгуулагдсан цагаасаа хойш төрд өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх оронч үзэл, итгэл үнэмшил, хүмүүжил, иргэний төлөвшил, тэсвэр хатуужлын сургууль болж ирсэн билээ.
Та бүхэн оролцсон

ажиллагаа, үүрэг гүйцэтгэсэн ээлж болгондоо эх орон, Зэвсэгт хүчнийхээ нэр төрийг өндөрт өргөж, хүлээсэн үүргээ цэрэг хүний ёсоор алдаа мадаггүй биелүүлэн, баатарлаг үйлс, бахархам гавьяагаа байгуулсаар байна. Ангийн анхны захирагч миний бие батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнтэй уулзахдаа та бүхний байгуулсан гавьяа, үйл хэргийг тань ямагт омогшин бахархаж нүүр бардам зогсдог юм. Энэхүү эрхийг эрэлхэг зоригтой та бүхэн олгосон билээ.
Үүсэн байгуулагдсан ойн баярын энэ өдөр байгуулсан гавьяа зүтгэл, шударга ариун хөдөлмөрийнхөө үнэлгээ болсон түүхээрээ гоёж сэтгэл зүрх нь догдлон байгаа дайчдадаа чин сэтгэлийн хүндэтгэл илэрхийлэн урт

насалж удаан жаргахын ерөөл дэвшүүлэе.
Та бүхний минь нугаршгүй ноён нуруу, бүтээсэн алдар гавьяа, дадлага туршлагын их өв сан Зэвсэгт хүчний хөгжлийн нэгэн тулгуур багана болсоор ирсэн цаашид ч байсаар байх болно.
Амжилт ололт, алдаа оноо бүрийн ард сэтгэл догдлон байдаг цэргийн алба хаагчдын ар гэрийнхэн та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэе.
Бахархах үйлсийн баялаг түүхтэй Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн эрэлхэг дайчид та бүхнийг өнө эртний түүхт Монгол цэргийн сүр хүч мөнхөд ивээж цог золбоо нь үеийн үед мандан бадрах өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Ж.МӨНХБАЯР

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн нийт офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, тус ангид алба хаасан үе үеийн ахмадууддаа анги үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлэе.
Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаа энэхүү түүхэн цаг үед Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний "Тусгай хүчний цэрэг" албан ёсоор байгуулагдсан түүхэн жил болж байна.
Монгол Улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг батлан хамгаалах үйлст үнэтэй хувь нэмэр оруулан, Монгол цэргийн түүхийг бахархам амжилтаараа өртөөлүүлж, эх орноо батлан хамгаалах хүндтэй үүргээ амжилттай биелүүлж байгаа мөрдөс нэгт та бүхэндээ Зэвсэгт хүчний 350 дугаар анги үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.
Монгол цэргийн сүлд хийморь мандан бадрах болтугай.



ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА Д.ӨЛЗИЙБАЯР

Манай амжилтууд

- Цэргийн сургалт бэлтгэлээр хошуучлагч анги-2020
- Биен тамир спортын тэргүүн анги-2019
- МУЕ, ЗХЕК-ийн нэрэмжит марш тусгай бэлтгэлийн тэмцээний аварга-2019, 2021
- Монгол цэргийн жавхаа дэд байр-2016
- Сахилгын зөрчилгүй тэргүүний хамт олон дэд байр-2020
- Биен тамир спортын нэгдсэн дүнгээр-2020, 2021
- Ажиллагааны удирдлагын газрын харьяа ангиудын Ротын марш тэмцээний аварга-2018
- Мотобуудлагын ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль-2019, 2020 "онц" дүнтэй
- АСЕМ-2016 хамгаалалт
- Бурхан халдуун уулын их овооны сэргээн босголт
- СИЗМ-2017 хамгаалалт
- ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины хамгаалалт
- Төрийн их баяр наадмын үйл ажиллагаа-2020
- Алтан орд цогцолборын бүтээн байгуулалт-2020

АНХНЫ ТОМИЛОЛТ БУЮУ ОТГОН АНГИ

Анги тулгаа тулахад анх ирсэн хуучуулын нэг ахмад Т.Эрдэнэсайхантай таарав. Одоо ротын захирагч албан тушаалтай тэрээр хүнгүй, байшингүй хоосон шахам газар ирж байснаа бодоход одоо манай анги сургалтын материаллаг бааз, гадаад дотоод тохижилтоороо жишиг болж чадсан хэмээн ихэд олзуурхана. Үнэхээр ч үний үр дүнд Зэвсэгт хүчний хэмжээнд сахилга бат, сургалт бэлтгэл, урлаг спортоор бусдыгаа манлайлж байгаа "Алдарын танхим"-д нь ирийтэл өрсөн өргөмжлөл, талархлууд гэрчилнэ. Ахмад Т.Эрдэнэсайхан 10 жилийн сургуулиа дүүргээд цэргийн сургуульд орох гэж өөрийгөө жилийн турш биеийн тамираар бэлдэжээ. Мөн Эрдэнэтийн унаган хүүхэд тэрээр хотынхоо төв талбайд болдог Цэргийн ёслолын жагсаалыг жил алгасалгүй үзэж би цэргийн хүн болно гэж найзуудтайгаа ам уралдан ярьцгаадаг байсан талаар нь ч хөөрөлдлөө. Гэрийнхнээсээ ганцаараа цэргийн мэргэжил эзэмшсэн болоод ч тэр үү бусдадаа их сонин, содон харагддаг аж. Басхүү хилийн чанадад үүрэг гүйцэтгэсэн ахмад Т.Эрдэнэсайхан бол өмнөхөөсөө өөр гэдгийн ялгаа заагийг ч их учирлаж хэлсэн. Бүтээн байгуулалтын ажилд оролцох, нийгмийн эмзэг бүлгийн өрхүүдэд гараа сунгах, ЕБС-ийн сурагчдад Зэвсэгт хүчин, цэргийн албаны талаар яриа таниулга хийх гээд тухайн орон нутагтаа иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх нь цаг ямагт нэн тэргүүнд тавигддаг зорилтуудын нэг. Ахмад Т.Эрдэнэсайхан эдгээр үйл ажиллагаанд тогтмол хамрагдахын зэрэгцээ хүүхэд залууст "Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд" гэх сэдвээр илтгэл тавьдаг. Илтгэл дууссаны дараа танхимд цугларсан олон хүүхдээс шижигнэсэн алга ташилт ирэхийн зэрэгцээ тэдэнд цэргийн хүн болъё гэсэн хүсэл эрмэлзэл их бага гэлтгүй төрдөг гэдгийг тэрээр хэлж байна лээ. Мөн хүүхдийн тэрхүү дэврүүн хүслийг унтраахалгүй улам их итгэл төрүүлэхэд цэргийн алба хаагч бид бүхэн чухал нөлөөтэй гэдгийг онцолсон юм.



ЦЭНХЭР ДУУЛГАТАН ЦЭРЭГ ЭРС

Үг, ая: МУАЖ Ө.Баярмагнай
Дуугаа дуулж жагсаалд жигдэрсэн Дуулгаа өмсөж тулаанд бэлтгэгдсэн Олон улсын Энхийн манаанд Оройн тоондоо жигдрэн жагссан Цэнхэр дуулгатай монгол цэргүүд Цэгцэрсэн жагсаалдаа энхийн дуутай Эх Орныхоо итгэлийг биелүүлж Элитийн батальон алхаж явна Хэрийн нутагт энхийг сахиулах Харьшгүй тангарагтай дайчин эрчүүд Халуун хүйтэнд шантарч няцаагүй Хатан зоригтой дайчин баатрууд Сайхан бүсгүйн сэтгэл шингэсэн Саруул орныхоо ирээдүйг хамгаалсан Олон улсад нэр нь тодорсон Онцгой үйлстэй дайчин баатрууд Аагим халуунд тэвчээр нь сулраагүй Аюул тохиолдоход итгэл алдаагүй Энгэр дүүрэн одон тэмдэгтэй Эрэлхэг цогтой дайчин баатрууд

ӨГЛӨӨ АЖИЛДАА ЯАРАН ИРЖ, ҮДЭШ ЯАРАН ХАРЬДАГ ТА ХАМГИЙН ЖАРГАЛТАЙ ХҮН

Хамгийн их ажил буцалдаг газар бол цэргийн ангийн гал тогоо юм. Тэгвэл энд сав угаагчаас, ээлжийн тогооч хүртэл "чанагдсан" хүн бол О.Цогзолмаа. Түүнийг анх ирэхэд байгуулагдаад удаагүй байсан тус анги гурван палатктай утгаж байсан нь олон жилийн өмнөх боловч эргэн дурсахад өчигдөрхөн мэт тодхон байдаг ажээ. Тэрээр "Тухайн үед хөгтэй юм их болно. Өглөө ирэхэд ус, мах, ногоо хөлдчихөөд, хэрчихэд хэцүү. Тоног төхөөрөмж гээд байх зүйлгүй. Дотор бэлтгэлээ хангаад гадаа том тогоонд хоолоо хийцгээдэг байлаа. Анхандаа хаана, ямар газар ирчээ ээ л гэж өөрөөсөө асуудаг байв. Иймэрхүү байдлаар хоёр, гурван жил болсон. Одоо ч дулаахан байртай, бүх зүйл бэлэн болохоор дутагдах гачигдах зүйлгүй сайхан л байна" хэмээсэн нь даарч хөрөхийн зовлонг бага гэлтгүй мэдэрсэн гэмээр. Өнгөрсөн хугацаанд түүнд төлөвшсөн зүйл бол ажлын төлөөх чин сэтгэл. Байнгын бэлтгэл, сургуулилт өдөр тутмын үйл ажиллагаа гээд бие бүрэлдэхүүний авдаг ачаалал тун их. Тиймээс тэр ачааллыг бууруулахад цэргийн гал тогооны цагаан нөмрөгтнүүд илчлэг сайтай, чанартай хоолоор үйлчилдэг. О.Цогзолмаа үүнийгээ ч ажил мэргэжлийнхээ нэгээхэн бахархал хэмээн үзнэ. Анх сав угаагч болоод тогоочоосоо номын дуу сонсож байсан О.Цогзолмаа бас өнөөдөр залуу үеэ хэрхэх билээ гэсэн асуултын хариултыг олохоор зүтгэж явна. Гал тогоонд мэдэхгүй чадахгүй зүйл байвал хамгийн түрүүнд "О.Цогзолмаа эгчээ" гээд зориод ирдэг хүн олон. О.Цогзолмаа анх амрыг бодож сав угаагч болж байсан нь хожим ачаалалтай, бэрх болсон тул ахлах тогоочийнхоо тавьсан саналыг эргэн харж, эхлээд бэлтгэгч тогооч болсон гэв. Шинэ хүн юм хойно, бүхнийг нэг дор сурчихгүй. Хоолоо ихдүүлэх, багадуулах гээд баримжаа алдах үе цөөнгүй байж. Одоо түүнийг харахад гарт орсон цагт ямар ч мэргэжил сайхан гэж бодогдохоор. Эхнээс нь өнөөдрийг хүртэл хамт зүтгэсэн болохоор О.Цогзолмаа хамт олондоо нүүртэй гэж жигтэйхэн. Тиймдээ ч дуртай ажлаа хийхээр өглөө яаран ирж, үдэш сайн эзэгтэйн үүргээ биелүүлэхээр мөн л яаран харьдаг О.Цогзолмаагийн талаар товч өгүүлэхэд ийм байна.

